



**НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
2026 ОНЫ ОНЦЛОХ АЖЛЫН ТАЙЛАН**

## НЭГ. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ

### 1. Үений дурангийн хагалгааг нэвтрүүлэв .

2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан үений мэс заслын дурангаар орон нутагт анх удаа Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмч нарын баг , НЭ-ийн гэмтэл согог заслын их эмч Б.Нямбаатар, сувилагч Жавзандулам нар хамтран мөрний үе болон өвдөгний үений дурангийн мэс заслыг амжилттай хийсэн. Мэс заслын тоо-2



2. Хэвлийн дурангаар бөөрний уйланхайг авах- Бөөрний уйланхайг анх удаа хэвлийн дурангаар авах мэс заслыг амжилттай хийсэн. Мэс засал-1 удаа
3. Цээжний хөндийн битүү гэмтэл, хавирганы хугарлыг бэхлэх мэс заслыг орон нутгийн эмч нар хийж эхэллээ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Хавсарсан гэмтлийн мэс заслын тасгийн эмч, мэргэжилтнүүд цээжний хөндийн битүү гэмтэл болон олон хавирганы тогтворгүй хугарлыг бэхлэх эмчилгээг эх орондоо улмаар хөдөө орон нутагт нутагшуулах уг ажлын үр дүнд Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн гэмтэл согогийн их эмч Г.Вандандорж, Э.Нямбаатар, Ч.Даваадорж, Мэс заслын эмч Д.Наранбаатар, Мэс заслын сувилагч Г.Гоомонголжин, Мэдээгүйжүүлэгч эмч Б.Баасанжав, Сувилагч Б.Нямсүрэн нарын баг цээжний хөндийн битүү гэмтэл, хавирганы хугарлыг бэхлэх эмчилгээг хийлээ. Ингэснээр осол гэмтлийн үед орон нутгийн иргэдэд цаг алдалгүй тусламж үйлчилгээ үзүүлэх, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын ачаалал, төвлөрлийг сааруулах чухал ач холбогдолтой юм.



### ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГАА



1. Гэмтэл согог судлалын үндэсний төвтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулав.  
2026.03.20